



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/30

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулж,
эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 4.1.6, 31 дүгээр зүйлийн 31.3, 60 дугаар зүйлийн 60.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, аймгийн Засаг даргын 2017 оны А/752 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын нэр бүхий иргэнээс түүний эзэмшлийн инженерийн шугам, сүлжээ бүхий газрыг дайруулан нэр бүхий иргэн хууль бусаар хашаа барьсан гэх өргөдөл ирүүлсэнийг судлан үзэхэд аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/182 дугаар захирамжийн 1 дэх заалтаар иргэн Нэргүйгийн Мөнхөө (РУ89122711)-д Мөрөн сумын 13 дугаар баг 35-16 тоотод байршилтай 6712015143 нэгж талбарын дугаар бүхий гэр, орон сууцны хашааны газрыг давхцуулан, инженерийн шугам, сүлжээ бүхий газрыг дайруулан олгосон байх тул эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ 322м² гэснийг 79.2м² гэж эзэмшил газраар дамжин өнгөрсөн дулааны шугамын хамгаалалтын талбайн хэмжээг хасаж тооцон газар эзэмшүүлэх хугацааг үлдсэн 10 жилээр эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/182 дугаар захирамжийн 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Нэргүйгийн Мөнхөө (РУ89122711)-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг гарсан өдрөөс хойш 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010191